



БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1/07

Улаанбаатар хот


2024 оны сар улирлын төсвийн хуваарь батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.11 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.12 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай" 91 дүгээр тогтоол, 2022 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 131 дүгээр тогтоол, 2023 оны "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай" 200 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/11 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Боловсролын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийн 3.3.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төсвийн хуваарилалтыг нэгдүгээр, төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагын төсвийн хуваарийг хоёрдугаар, төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагад хуваарийн дагуу санхүүжилтийг олгохыг Санхүү, төсвийн хэрэгжилт, зохицуулалтын газрын санхүүгийн тайлангийн нэгтгэл, бүртгэл хариуцсан ахлах нягтлан бодогч буюу ахлах мэргэжилтэн (Г.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Санхүү, төсвийн хэрэгжилт, зохицуулалтын газар (Ж.Энхтөр)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Чинтогтох)-т тус тус даалгасугай.



2024.01.15

